

# МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ БА УЛС ТӨРИЙН

## ҮЙЛ ЯВЦ

МУБИС-ийн Улс төр судлал, социологийн тэнхим  
Доктор (PhD) Н.Мягмарцоож

### Мэдээлэл холбооны технологийн тухай ойлголт

1970-аад оны дунд үеэс Мэдээлэл, холбооны технологи (Information Communication Technologies - **ICT**) болон тэдгээрийг хөгжилд ашиглах нь аажмаар нэмэгдсэн. АНУ болон баруун Европын хэд хэдэн орон мэдээллийн нийгэмтэй болж, өөрөөр хэлбэл мэдээллийн программ хангамж болон техник хангамжийг түгээх, боловсруулах, үйлдвэрлэх зэрэг нь эдгээр орны гол үйл ажиллагаа болсон. (Рожерс 1986). **Мэдээлэл Холбооны Технологи (МХТ)** нь электроник утгаараа мэдээлэл солилцох, хадгалах, боловсруулах, цуглуулах үйл явцыг хэлнэ (Хикс 1999). Тоон мэдээлэл холбооны технологи нь мэдээллийн нэг болон тэг хэлбэрт хадгалж, өгөгдлийг цахилгаан холбооны сүлжээгээр дамжуулдаг байна. Мэдээлэл нь электрон дохио хэлбэрээр байдаг, мөн электрон соронзон долгионоор дамждаг аналог системтэй радио, телевиз зэрэг нь мэдээлэл холбооны “хуучин” технологи юм. Дижитал буюу тоон **МХТ** гэдэгт утас, утасгүй үүрэн телефон утас, мэдээлэл холбооны хиймэл дагуул, компьютер болон интернет багтана.

Мэдээлэл холбооны технологийн хөгжлийн давуу талууд:

- Хэрэглэгчдийн дэлхийн зах зээлд нэвтрэх, мэдээлэл олж авах хамгийн том гарц болдог,
- Цаг хугацаа хэмнэж, орон зайг товчилж чаддаг нь эдийн засгийн өндөр үр ашгийг авчирдаг,
- Харилцан мэдээлэл солилцох өргөн боломжийг бий болгодог,
- Хүмүүс хоорондын харилцааг бэхжүүлж, идэвхижүүлдэг.

### Дэлхийн чиг хандлага

2011 оны байдлаар дэлхий дээрх үүрэн телефон хэрэглэгчийн тоо 6 тэрбумд хүрч, интернэтийн бүртгэлтэй хэрэглэгчийн тоо 590 сая болж, 2,4 тэрбум хүн интернэт ашигладаг болжээ. Сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн бүс нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн хувьд илүү давуу хөгжилтэй бүс нутаг болон хөгжиж байна. Тус бүс нутгийн телефон шугамын тоо хоёр тэрбумаас давж, хөдөлгөөнт холбооны хэрэглэгчийн тоо 1.4 тэрбумд хүрсэн үзүүлэлт гарчээ. 2008 оны хагас жилийн байдлаар дэлхийн нийт хөдөлгөөнт холбооны хэрэглэгчдийн дөрөвний нэг хувийг Хятад болон Энэтхэг улс эзэлсэн тооцоо гарсан. Дэлхийн интернэт хэрэглэгчийн 40 хувийг Ази, Номхон Далайн бүс хамрах бөгөөд интернэтийн өргөн зурвасын дэлхийн зах зээлийн 39 хувийг эзэлж байна. НҮБ-ын гишүүн улсуудыг хамруулсан цахим засаглалын судалгааг жил бүр хийдэг. Энэхүү цахим засаглалын хөгжлийн судалгааг гаргахдаа:

1. Онлайн үйлчилгээ (онлайн агуулгын хөгжил, үндэсний портал сайтын тоо, төрийн байгууллагуудын онлайн үйлчилгээ)
2. Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц ( ОУЦХБ-аас гаргадаг 100 хүнд ногдох интернэт хэрэглэгчийн тоо, 100 хүнд ногдох суурин телефон цэгийн тоо, 100 хүнд ногдох

үүрэн телефон хэрэглэгчийн тоо, 100 хүнд ногдох интернэтийн бүртгэлтэй хэрэглэгчийн тоо)

3. Хүний хөгжил (НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн Сан зэрэг байгууллагуудаас гаргасан судалгаа) зэргийг харгалзан үздэг ажээ.

Улс төрийн үйл явц цахим сүлжээнд шилжсэн нь дэлхийн улс түмэн төр засгаа сонгон бүрдүүлэх, улс төрийн эрхээ эдлэх болон цахим сүлжээ ардчилах үйл явцад хэрхэн нөлөөлж байгааг судлах *дигитал ардчилал*<sup>1</sup>, *электрон ардчилал*<sup>2</sup> зэрэг судлагдахууны шинэ аспект хэдийнээ бий болжээ.

Энэхүү цахим засаглалын хөгжил тухайн орны хөгжлийн түвшинг илэрхийлдэг нэгэн томоохон үзүүлэлт болдог учир улс орнууд тэргүүлэх ач холбогдол өгдөг.

### **Монгол Улсын нөхцөл байдал**

2005 оноос Монгол Улсад мэдээлэл холбооны технологийг хөгжүүлэх талаар томоохон алхамуудыг эрчимтэй хийж эхэлсэн бөгөөд тухайн үед дараах чиглэлүүдийг тэргүүлэх чиглэл болгон тавьж байсан нь өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй байна. Үүнд:

- Цахим засаг
- Цахим арилжаа
- Цахим үйлдвэрлэл
- Цахим боловсрол
- Цахим иргэний нийгэм
- Цахим эрүүл мэнд оржээ.

Үүрэн телефон холбооны салбарт 4 оператор компани тогтвортой үйл ажиллагаа явуулан Монгол Улсын нийслэл хот, 21 аймаг, 330 сум, сууринд үйлчилгээгээ хүргэж байна. Өнөөгийн байдлаар үүрэн телефон холбооны орлогосалбарын нийт орлогын 70 хувийг дангаараа бүрдүүлж, хэрэглэгчдийн тоо 2011 онд 2.9 сая хүрч 2008 оноос 65 хувиар өсчээ.

Монгол Улсад интернэтийн үйлчилгээ 1996 оны 1 дүгээр сарын 17- ны өдөр анх нэвтэрснээс хойш 17 жилийн хугацаа өнгөрчээ. Интернэтийн зах зээлд 85 байгууллага үйлчиллагаа эрхэлж, интернэт хэрэглэгчдийн тоо жил бүр нэмэгдсээр байна. Интернэтийн бүртгэлтэй хэрэглэгчдийн тоо 2011 онд 457.6 мянга хүрч 2008 оноос 11 дахин өсчээ.

2010 оны тооллогоор хүн амын хүн амын 30,6% нь интернэт ашиглаж хэрэглэгчдийн тоо 709.6 мянга болсон дүн гарчээ.

Монгол Улсын хэмжээнд 2009 онд интернэтийн нэг гарцтай, хүчин чадал нь 3,7 Гб/с байсан бол одоо 6 гарцтай болж 17,2 Гб/с буюу 5 дахин нэмэгдсэн өндөр хурдаар дэлхийн мэдээллийн сүлжээнд холбогдож байна.

Техник, технологи, сүлжээний өргөтгөл, шинэчлэлт, үнэ тарифын хямдралтай холбоотой мэдээллийн технологийн хэрэглээ төрөл, зүйлээрээ өссөөр байна. Тухайлбал, Интернэтэд

<sup>1</sup>The Myth of Digital Democracy. Matthew Hindman. Copyright. New Jersey., 2009

<sup>2</sup>Social Informatics: An Information Society for All: In Remembrance of Rob Kling. Jacques Berleur, Markku I. Nurminen, John Impagliazzo. Copyright. USA., 2006

суурилсан фэйсбүүк, твиттер, ютүб, википедиа, бизнетворк зэрэг олон нийтийн сүлжээнд монголчууд олноор нэгдэж өргөнөөр ашиглаж байгаа билээ.

Монгол Улсад интернэтэд суурилсан олон нийтийн сүлжээ бизнетворк (<http://www.biznetwork.mn>) цахимхуудаснь Монголын чадварлаг мэргэжилтнүүд, бизнес эрхлэгчдийг хооронд нь ажил хэргийн зорилгоор холбох платформыг бий болгох уриатайгаар үйл ажиллагаагаа эхэлсэн ба өдгөө 120 мянган хэрэглэгчидтэй болжээ.

Facebook сүлжээний хэрэглэгчид 2012 оны 6-р сарын байдлаар 417 мянга болжсүүлийн 6 сард 132 мянган хэрэглэгч нэгджээ. (эх сурвалж <http://www.socialbakers.com>)

Монголын facebook хэрэглэгчдийг насны ангилалаар авч үзсэн судалгаанаас харахад 18-35 насныхан хэрэглээ өндөр байна.

Шуудангийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь шуудангийн үйлчилгээний технологийн чанартай, найдвартай, шуурхай байдлыг хангах, дэлхийн шуудангийн үйлчилгээний технологийн хөгжилд хөл нийлүүлэх үүднээс шуудангийн Web, Email, Ftp, PostNet, Application, Мэдээллийн сан бүхий серверүүдийг зохион байгуулж хэвийн ажиллагаагаар хангаж Олон улсын шуудан холбооны гадаад шуудан бүртгэл, тооцооллын IPS light систем, санхүү бүртгэлийн Vinnica програм хангамж, хэвлэлийн захиалга нэгтгэлийн OrdersPro зэрэг томоохон програм хангамжийг нэвтрүүлжээ.

## **Улс төрийн үйл явцад мэдээлэл холбооны технологийг ашиглаж буй**

### **өнөөгийн байдал**

Дэлхийн цахилгаан холбооны байгууллагаас 2005 онд дээд хэмжээний чуулган хийж ойрын, дунд болон урт хугацааны зорилтуудыг дэвшүүлжээ<sup>3</sup>. Монгол Улсын “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д “Мэдээлэл, харилцаа холбооны технологийг Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 21 дүгээр зууны үндсэн хурдасгуур гэж үзнэ” гэж тодорхойлсон нь түүхэн ач холбогдол бүхий эрхэм зорилго бөгөөд үүн дээр тулгуурлан Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн талаар 2021 он хүртэл төрөөс баримтлах бодлогыг тодорхойлжээ. Энэхүү бодлогын баримт бичигт: “Цахим Засгийн газар ба засаглалыг дэмжин хөгжүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, ил тод, тунгалаг, хүртээмжтэй болгох”, “Бодлого тодорхойлох, хөтөлбөр хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын эргэх холбооны үндэсний, бүсийн, салбарын, хэлтэс газрын түвшний харилцаа холбооны систем, мэдээллийн санг МХХТ-ийг ашиглан байгуулах” хэмээн тусгажээ.

Монгол Улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт (2004-2008) хууль тогтоол болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон бусад актын төслийг боловсруулах явцад цахим хэлбэрээр иргэд ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдээс санал авах талаар журам боловсруулна гэжээ. Мөн 2008-2012, 2012-2016 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрүүдэд өндөр технологи, био, нано, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, цахим засаглалы хөтөлбөрийн талаар тусгасан байна.

<sup>3</sup>World Telecommunications/ICT Development Report 2010, Monitoring the WSIS Targets A mid-term review. P10.

Авлигын эсрэг хууль болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиудад төрийн байгууллагуудыг өөрийн гэсэн вэб хуудастай байх, түүнд зохих мэдээллүүдийг тавьж түүнээ шинэчилж байх үүргийг оноосон явдал нь эрх зүйн хувьд гарсан томоохон дэвшил гэж үзэж болохоор юм.

2009 онд иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээллийг олон нийтэд мэдээлж байхыг хуульчилсан. Энэ дагуу төрийн байгууллагууд иргэдийн өргөдөл гомдлыг цахим хэлбэрээр авч болохын зэрэгцээ хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээллээ өөрийн цахим хуудсандаа байрлуулах үүрэг хүлээсэн байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн /2011/:

15.1-д: Иргэн, хуулийн этгээд цахим хэлбэрээр мэдээлэл авах хүсэлт гаргаж болно.

15.2-д: Цахим хэлбэрээр мэдээлэл авах хүсэлт гаргасан тохиолдолд иргэн, хуулийн этгээд нь цахим баримт бичиг үйлдэн, тоон гарын үсэг зурах бөгөөд түүнд өөрийн иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаарыг бичиж, холбогдох байгууллагад цахим шуудангаар ирүүлсэн байна.

15.3-д: Мэдээллийг цахим хэлбэрээр иргэн, хуулийн этгээдэд өгөх тохиолдолд тухайн байгууллагыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурах бөгөөд хүсэлт гаргагчид мэдээллийг цахим шуудангаар хүргүүлнэ хэмээн тус тус заажээ.

*Нэг.Төрийн байгууллагууд:*

**Цахим –засаглал :** Цахим засаглалын функцэд гурван үндсэн үйлчилгээ байдаг<sup>4</sup>.

1. Мэдээллийн үйлчилгээ. Вэб хуудсанд олон нийтэд зориулсан мэдээллийн санг үүсгэсэн байдаг.
2. Харилцааны хэсэг. Е-майл болон чат өрөөг ашиглан иргэдийн санал хүсэлтийг авах, асуултанд хариулах, хэлэлцүүлэг өрнүүлэх зэрэг үйл ажиллагаа явагддаг.
3. Гүйлгээ хийх үйлчилгээ. Төрийн үйлчилгээнд хамрагдах бөгөөд төлбөрт үйлчилгээ явуулах зорилготой.

**Цахим – оролцоо:** Орчин үед техник технологийн өндөр хөгжилтэй уялдан цахим-оролцооны тухай асуудал яригдах болж, тэр чиглэлээр олон арван судалгаанууд хийгджээ. Иргэдтэйгээ харилцаагаа бэхжүүлэхийг эрмэлзсэн засгийн газрууд мэдээлэл холбооны шинэ технологид гол анхаарлаа хандуулж, ихээхэн итгэл найдвар тавьж байна<sup>5</sup>. Мэдээлэл холбооны технологи гэдэг бол цахим тооцоолуур, мониторинг суурилсан холболтууд, мэдээллийн сан, программ хангамжууд тэдгээрийг өөр хооронд нь холбогч сүлжээнээс бүрддэг. Эдгээр нь цахим оролцооны гол хэрэгсэл болдог. Мэдээллийн техник технологи эрчимтэй хөгжиж байгаа өнөө үед цахим оролцоо нэмэгдэж улмаар цахим ардчиллын тухай асуудал гарч ирж байгаа юм. Энд мэдээлэл холбооны технологийг өргөн хэрэглэх нь ардчиллын нэгэн чухал стратеги болж байгааг харуулж байна. Цахим ардчилал нь дэлхий нийтийн, үндэстний, орон нутгийн улс төрийн үйл явцад бүгдэд нь чухал үүрэгтэй болж, засгийн газар, улс төрийн бүлэглэлүүд, хувийн хэвшлүүд, хэвлэл мэдээлэл, зар сурталчилгааны хүрээн дэх цахим-иргэнийг бий болгож байна.

<sup>4</sup> Thomas F, Gordon. Fraunhofer. FOCUS. E-Government.

<sup>5</sup>Марк Грамбергер. 2003. *Иргэн тіншлэгч болох нь: Бодлого боловсруулах явцад мэдээлэх, зөвлөлдөх, олон нийтийг оролцуулах*. УБ: ННФ, х 78

## Цахим иргэн



Сүүлийн үеийн хандлагаас харахад бодлогын үйл явцад иргэдийн оролцоог хангахад томоохон бааз суурь болж байгаа хэрэгсэл нь мэдээлэл холбооны технологи гэдэг нь нэгэнт тодорхой болжээ. Энэ нь мэдээлэл холбооны технологийн эрчимтэй хөгжлийн үр дүнтэй холбоотой юм.

2010 онд НҮБ-аас цахим-засаглалын хүрээнд хийсэн судалгааны үр дүнг дор үзүүлэв.

### Хүснэгт 3үүн Азийн цахим засаглалын хөгжил

	Улс орон	Цахим-засаглалын хөгжлийн индекс		Дэлхий нийтийн цахим засаглалын хөгжлийн индекс	
		2010	2008	2010	2008
1	БНСУ	0,8785	0,8317	1	6
2	Япон	0,7152	0,7703	17	11
3	Монгол	0,5243	0,4735	53	82
4	БНХАУ	0,4700	0,5017	72	65
5	БНАСАУ	...	...	...	...
	Бүсийндундаж	0,6470	0,6443		
	Дэлхийндундаж	0,4406	0,4514		

Дээрх судалгаанд Монгол Улс цахим засаглалын индексээр 0,5243 гэсэн үзүүлэлтээр 53 - рт оржээ. Үүнд: интернет үйлчилгээний үзүүлэлт, цахилгаан холбооны дэд бүтцийн үзүүлэлт, хүний капиталын үзүүлэлт оржээ. Харин интернет үйлчилгээний индекс болон үзүүлэлтээр 190 орноос 122-торжээ.

### Хүснэгт 8. Цахим оролцоо (e-participation) эхний 20-дорсон улс орон

д/д	Улс орон	Оролцооны индекс	2010 оны үзүүлэлт	2008 оны үзүүлэлт	Өөрчлөлт +/-
1	БНСУ	1,0000	1	2	+1
2	Австрали	0,9143	2	5	+3
3	Испни	0,8286	3	34	+31
4	Шинэ Зеланд	0,7714	4	6	+2
5	Нэгдсэн Вантулс	0,7714	4	25	+21
6	Япон	0,7571	6	11	+5
7	АНУ	0,7571	6	1	-5
8	Канад	0,7286	8	11	+3
9	Эстони	0,6857	9	8	-1

10	Сингапур	0,6857	9	10	+1
11	Бахрейн	0,6714	11	36	+25
12	Малайз	0,6571	12	41	+29
13	Дани	0,6429	13	3	-10
14	Герман	0,6143	14	74	+60
15	Франц	0,6000	15	3	-12
16	Нидерланд	0,6000	15	16	+1
17	Бельги	0,5857	17	28	+11
18	Казакстан	0,5571	18	98	+80
19	Литва	0,5286	19	20	+1
20	Словени	0,5143	20	55	+35

Монгол Улсад сүүлийн жилүүдэд мэдээлэл холбооны технологи эрчимтэй хөгжиж хэрэглэгчдийн тоо өссөөр иржээ. Тухайлбал:

*Гар утас хэрэглэгчдийн тоо:*

2004-2006 онд 500 000

2007-2008 онд 1,194,000

2010 онд 1,714,645 буюу нийт хүн амын 74% болжээ.

*Интернет хэрэглэгчдийн тоо:*

2009 онд нийт хүн амын 13%-ийг эзэлж байсан бол

2010 онд 709,625 буюу хүн амын 30,6%-ийг эзэлж байна

УИХ-ын [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим хуудсанд хуулийн төсөлд иргэдийн саналыг хүлээн авдаг булан ажиллаж байна. Энд иргэдийн хуулийн төсөлд өгсөн саналууд нь нээлттэй байх бөгөөд цахим шуудан, архив, номын сангууд ажиллаж байна. Зарим УИХ-ын гишүүд (2012 оны 06 сарын байдлаар 9 гишүүн цахим хуудастай байсан) өөрийн цахим хуудсанд иргэдийн санал бодлыг хүлээн авдаг хэсэг ажиллуулж байгаа юм.

Засгийн газрын [www.open-government.mn](http://www.open-government.mn) цахим хуудсанд засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудалд саналаа өгөх боломжийг иргэдэд бий болгожээ.

Энэ бүхэн нь иргэдийн санал хүсэлтийг бодлого боловсруулах үйл явцад цахим хэлбэрээр авч буй сайн туршлага боловч нэгэн нийтлэг дутагдал байгаа юм. Өөрөөр хэлбэл иргэдийн саналыг хэрхэн тусгасан тухай эргэж мэдэгддэг тогтолцоо байхгүй байна.


Монгол Улсын Ерөнхийлөгчийн [www.president.mn](http://www.president.mn) цахим хуудсанд Иргэний танхим иргэдийн саналыг цахим хэлбэрээр авах, буцааж хариуг хэрхэн өгөх талаарх дүрэмийг тодорхой тусгажээ. Мөн иргэний танхимаар хэлэлцэх асуудлаар цахим хэлэлцүүлэг хийдэг байна.

Энэ бүгдээс гадна УИХ, ЗГ-ын гишүүд, бодлого боловсруулагчид facebook, twiter, blog зэрэг цахим харилцааны хэрэгсэлүүдийг ашиглан олон нийтийн санаа бодлыг хүлээн авах, түгээх, санал солилцох аргыг хэрэглэж эхэлж буй нь иргэдийн цахим оролцоог нэмэгдүүлэхэд түлхэц үзүүлэх хүчин зүйл юм.

## Төрийн байгууллагын веб сайт: өнөөгийн байдал (2010, 2011 он)

Судалгаагаар<sup>6</sup> вэб сайтын ил тод байдлыг хэмжих үндсэн таван шалгуураар монголын нийт 100 төрийн байгууллагын вэб сайт (4 вэб сайт тодорхой шалтгаанаар шинжилгээ хийгдэх боломжгүй болсноор хасагдаж нийтдээ 96 вэб сайт дээр шинжилгээ хийгдсэн юм) хэр ил тод байгааг бүхэлд нь үнэлэхэд төрийн байгууллагын вэб сайтууд бүхэлдээ 40 хувь буюу ил тод бус, хаалттай гэсэн үнэлгээ авчээ. Энэ нь ил тод байдлыг үнэлэх үнэлгээний хамгийн доод шат буюу муу гэсэн ангилалд хамаарах дүн юм.

### Шалгуур бүрийн дүн



Вэб сайтыг ашиглахад хялбар байдал буюу вэб сайтын техникийн талын үзүүлэлт 64 хувь буюу хамгийн өндөр дүнтэй байгаа бол мэдээллийн найдвартай байдал болох вэб сайт дахь мэдээллийн эх сурвалж, баттай мэдээлэл нь 6.9 хувь буюу хамгийн бага дүнтэй байна. Энэ нь хэдийгээр вэб сайт техникийн хувьд өсөн дэвжиж байгаа боловч доторх мэдээллийн чанар, найдвартай байдал дээр анхаарах хэрэгтэйг харуулж байна.

Ингээд хэсэг бүр дээр гарсан дүгнэлтийг танилцуулж байна.

1. Мэдээллийн холбогдолтой байдал (Relevance)– 2011 онд гарсан үр дүн 2010 оныхоос төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Гэвч байгууллагын цахим шуудангийн хаяг, олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр, албан тушаалын талаарх мэдээлэл тавигдах нь сайжирсан байна. Уг үзүүлэлт бүхэлдээ 50 хувьтай биелэгджээ.

2. Мэдээллийн найдвартай байдал (Reliability) – судалгааны дүнгийн хувьд хамгийн муу буюу 6 хувьтай гарсан энэхүү хэсгийг дүгнэн хэлэхэд вэб сайтын мэдээлэл хэрэглэгч, иргэдэд хүрэхдээ ямар нэг эх сурвалжгүй буюу найдваргүй байдлаар хүрч байна. Ялангуяа төсөв, санхүүгийн мэдээлэл уг үзүүлэлтээр хангалтгүй гарчээ.

<sup>6</sup>НҮБ. Авлигатай тэмцэх газар. ЗГХЭГ, IRIM ТББ. “Төрийн байгууллагын вэб сайтын ил тод байдал” \мониторингийн тайлан\ УБ., 2012.

3. Мэдээллийн цаг үеийн байдал (Timeliness) –дэд гурван үзүүлэлтээр уг шалгуурыг хэмжсэн бөгөөд вэб сайтууд бүхэлдээ дунджаар 35 хувийн үзүүлэлттэй гарсан.

4. Мэдээллийн хүртээмжтэй байдал (Accessibility) – дөрвөн үзүүлэлтээр хэмжсэн. Судалгааны дүнд төрийн байгууллагын вэб сайтууд уг үзүүлэлтээр 46 хувьтай байгаа ба вэб сайт нь зарим талаар л хэрэглэгчдэд хүртээмжтэй байна. Хэдийгээр 2010 оны дүнтэй харьцуулахад дөрвөөс гурван үзүүлэлт нь сайжирсан, эерэг үзүүлэлттэй байгаа боловч мэдээлэл зөвхөн нэг талын урсгалтай байгаа бөгөөд төрийн байгууллагууд эргээд иргэдийн оролцоог хангах, тэднийг сонсох тал дээр дутагдалтай байна.

5. Вэб сайтыг хэрэглэхэд хялбар байдал (Usability) –судалгааны дүнгээр хамгийн өндөр буюу 64 хувьтай гарсан хэсэг юм. 2010 онтой харьцуулахад онцгой өөрчлөлт гараагүй үзүүлэлт хэвээр хадгалагдаж байв. Төрийн байгууллагын вэб сайт хэрэглэхэд хялбар байгаа нь техникийн талаараа бусад үзүүлэлтээс давуу байгааг харуулж байна.

#### *Хоёр. Улс төрийн сонгуульд:*

Улс төрийн намууд болон нэр дэвшигчид сонгуулийн үед сонгогчидтой идэвхитэй байнгын харилцаа тогтоох нэгэн хэрэгсэл нь интернэт дахь вэб сайт болж байдаг. Интернэт сүлжээний давуу талыг ашиглан сонгуулийн сурталчилгаа хийх, сонгогчидтой харилцахад ашиглаж байгаа улс төрийн нам болон нэр дэвшигчийн зүгээс хийдэг цогц үйл ажиллагааг вэб кампанит ажил \web campaigning, e-campaigning\ гэж нэрлэх нь бий. Вэб кампанит ажил гэдэг нь сонгуулийн үед ашиглаж байгаа улс төрийн нам, нэр дэвшигчийн интернэт дахь вэб сайтын бүтэц, хэлбэр, агуулга дизайн нь сонгогчид шийдвэр гаргахад нь нөлөөлөх зорилготой хийгддэг олон төрлийн улс төрийн сурталчилгаа, улс төрийн маркетинг, олон нийтрүү чиглэсэн PR-ийн үйл ажиллагааны нэгдэл байна.

Судлаач Жүдит, Трент, Роберт Фрейденобэрг нарын үзэж байгаагаар вэб сайт дараах үүргүүдийг томъёолжээ. Үүнд:

- Сонгогчдыг нэр дэвшигчдийн талаарх мэдээллээр хангах,
- Мөнгө цуглуулах (сонгуулийн болон улс төрийн кампанит ажилд зориулан сонгогчдоос хөрөнгө санхүү татах),
- Тодорхой асуудлаар нэр дэвшигч ямар байр суурьтай байгаа талаарх мэдээллийг сонгогчдод хүргэх,
- Улс төрийн болон сонгуулийн кампанит ажлын улс төрийн мэдээ, мэдээлэл түгээх,
- Сонгогчдыг сонгуулийн үйл явцын талаарх мэдээллээр хангах,
- Нэр дэвшигч дэмжигчдийг хооронд нь холбох,
- Сайн дурынхныг нэр дэвшигчдийн кампанит ажилд элсүүлэх,
- Нэр дэвшигчтэй харилцаа холбоо тогтоох, мэдээлэл өгөх,
- Тодорхой асуудалд хандаж буй сонгогчдын санаа бодлыг танадах,
- Өрсөлдөгчрүү хандсан үйл ажиллагаа явуулах<sup>7</sup> зэрэг оржээ.

МХТ-ыг ашигладаг иргэдийн тоо өсөн нэмэгдэж байгаа өнөө үед сонгуулийн кампанийн үйл ажиллагаа МХТ-ыг ашиглахад чиглэгдэх нь зүйн хэрэг юм. Сүүлийн жилүүдийн

---

<sup>7</sup> Judith S.Trent, Robert V. Freidenberg “Political Campaign Communication: principles and practices”. 2008. USA.



Монголын сонгуулиудын үйл явцыг ажиглахад өмнөх жилүүдээ бодвол вэб сайт, твиттэр, фесбүүк, цахим шуудан зэргийг сонгуулийн сурталчилгаа хийх, хэлэлцүүлэг өрнүүлэх, санал асуулга явуулах зэргээр ашиглах явдал нэмэгдэж байна. Гэвч хэрэглэгчид болон техник технологийн боломжтой харьцуулахад харьцангуй бага байгаа юм. Энэ нь хэрэглэгчдийн хэрэгцээ сонирхол, сонгуулийн кампанийн чадавхи, нөөц бололцоотой холбоотой болов уу?

*Гурав. Улс төрийн намын үйл ажиллагаанд:*

Мэдээлэл холбооны технологи өндөр хөгжсөн өрнөдийн улс төрийн намууд аль болох намын вэб сайтруу хандах сонгогчдын тоог өсгөх, тэдгээр сонгогчдын утасны дугаар, мэйл хаяг зэргийг цуглуулан дэмжигчдийн бааз бүрдүүлэхэд анхаарч, олон төрлийн сонирхолтой хэлэлцүүлэг зохиох, арга хэмжээнд уриалах замаар тэдний дэмжлэгийг олж авдаг байна.

2007 онд дэлхийн өндөр хөгжилтэй болон хөгжиж буй 196 оронд хийсэн судалгаагаар<sup>8</sup> 3084 улс төрийн намыг хамруулсан бөгөөд тэдгээрийн 48% нь үйл ажиллагаандаа вэб сайт ашиглаж байсан байна. Энэ тоо 2000 онд 1284 улс төрийн намын 39%, 2005 онд 1668 улс төрийн намын 46% нь вэб сайт ашиглаж байсан гэсэн харьцуулсан судалгааны дүн гарчээ.

Улс төрийн коммуникацийн судалгаанд улс төрийн намууд интернэт сүлжээг ашиглах нь улс төрийн үйл явцад эерэг нөлөө үзүүлдэг болохыг А. Колеман (2003), П. Норрис (2008), Д. Лилкер (2009) нарын судлаачид тэмдэглэсэн. Тус судалгаа нь арга зүйн дээрх чиглэлүүдээс улс төрийн намын вэб сайтыг улс төрийн коммуникацийн хэрэгсэл болох талаас нь анализ хийх “Зургаан талт кибр харилцан үйлчлэлийн загвар<sup>9</sup>”-т тулгуурласан болно. Америкийн “Рочестер технологийн хүрээлэн”-ийн судлаач П. Фербер, Ф. Флотц нар судлаач Мак Милланы<sup>10</sup> интернэт сүлжээн дэх хүмүүс хоорондын харилцан үйлчлэлийн дөрвөн талт загварыг илүү нарийвчлан улс төрийн институт, улс төрийн нам нь өөрийн вэб сайтаар олон нийтэд мэдээлэл түгээгээд зогсохгүй интернэт орчин дахь хүмүүс хоорондын улс төрийн аливаа асуудлаарх хэлэлцүүлэгийг удирдан чиглүүлэх, өдөөх, тэрхүү хэлэлцүүлэг явуулах боломж бүрдүүлэх үүргийг гүйцэтгэх нь зүйтэй хэмээн үзжээ.

Судлаач Т.Туяачимэг сүүлийн нэг жилд вэб сайт нь тогтмол үйл ажиллагаатай МАН-ын [www.nam.mn](http://www.nam.mn), АН-ын [www.demparty.mn](http://www.demparty.mn) сайтыг сонгон авч судалсан байна. Тэрээр улс төрийн намуудын вэб сайтад намаас сонгогч, олон нийтэд мэдээлэл түгээх 10 үзүүлэлт, намын дотоод сүлжээг шалгах 1 үзүүлэлт, намын нөөц, дэмжигчдийг өөртөө элсүүлэх боломжтой эсэхийг хэмжсэн 6 үзүүлэлт, сонгогчид намын вэб сайтаар дамжуулан намтай харилцах бололцоог хангасан эсэхийг хэмжих 20 үзүүлэлт, вэб сайтыг мэргэжлийн


<sup>8</sup>Routledge Handbook of Internet Politics. Andrew Chadwick, N. Howard. Copyright. USA., 2009

<sup>9</sup>Cyberdemocracy and Online Politics: A New Model of Interactivity. Paul Ferber, Franz Foltz, Rudy Pugliese. “Bulletin of Science, Technology & Society”. Vol. 27, No. 5, October 2007., p. 391-400

<sup>10</sup>A four-part model of cyber-interactivity. McMillan, S. J. New Media & Society. Copyright., 2002. № 4(2), p. 271-291


дизайнчлалыг шалгах 6 үзүүлэлт тус бүрээр нийт 43 үзүүлэлтийг анализ хийхэд ашигласан байна.

### МАН, АН-ын вэб сайтын анализийн дүн



МАН ба АН интернэтийн вэб сайтыг иргэд, сонгогч дэмжигчидтэй харилцах улс төрийн коммуникацийн хэрэгсэл болгон ашиглаж байна уу гэдэг асуултад нийт 43 шалгуур үзүүлэлтээс МАН 18, АН 19 үзүүлэлтийг хангажээ. Ерөнхий байдлаар дээрх хоёр намын вэб сайт ойролцоо тоон үзүүлэлттэй харагдаж байгаа хэдий ч үзүүлэлт тус бүрээр авч үзвэл ялгаатай байдал ажиглагдсан байна.

### МАН, АН-ын вэб сайт иргэдийн улс төрийн оролцоог хангаж буй эсэхийг хэмжсэн анализийн дүн



Дээрх диаграммаас харахад намууд ижил хувьтай үзүүлэлтийг хангасан хэдий ч зөвхөн нам тус бүрт ялгаатай байсан үзүүлэлтийг авч үзье.

### Иргэдийн улс төрийн оролцоог хангасан эсэхийг хэмжих зарим үзүүлэлт

Иргэдийн оролцоог хангасан эсэхийг хэмжих зарим үзүүлэлт	МАН	АН
Намын парламентад сонгогдсон гишүүдтэй холбогдох ерөнхий мэдээлэл бий эсэх	1	0
Намын парламентад сонгогдсон гишүүдтэй холбогдох онлайн холбоос \application бий эсэх	1	0
Намын парламентад сонгогдсон гишүүдтэй утсаар холбогдох боломжтой эсэх	1	0

Намтай шууд холбогдох телефон утасны дугаар бий эсэх	0	1
Намын үйл ажиллагаатай холбоотой ерөнхий санал асуулга явуулж байгаа эсэх	0	1
Намын вэб сайтгүй нэвтрэх тусгай хаалга бий эсэх \Login\	0	1

Монголын улс төрийн намуудын ашиглаж буй вэб сайтад хийсэн анализийн дүнгээс үзвэл улс төрийн намууд сонгогчидтой харилцахад вэб сайтыг 40%-тай ашиглаж байна. Намууд интернэтийн вэб сайтыг “Мэдээллийн самбар” мэт үзэж байгаа нь учир дутагдалтай. Цаашид сонгогчидтой идэвхитэй, байнгын улс төрийн харилцаа тогтооход чиглэсэн улс төрийн намын вэб сайтыг шинэчлэх шаардлагатай гэж үзжээ.

### **МХТ-ийн хөгжилд анхаарах асуудлууд**

#### **Цахим засгийн үйл ажиллагаа нь:**

- 1) Төр засгийн зүгээс явуулах МХТ-ийн бодлого төлөвлөлт, хэрэгжүүлэлт, зохицуулалт, хяналтын механизм, бүтцийг тодорхой болгох
- 2) Төр, засгийн байгууллагуудаас олон нийттэй харилцах үйл ажиллагаандаа зарчмын шинэ өөрчлөлт хийх (public sector reform)
- 3) Төрийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах (government database)
- 4) Төрийн бүх шатны албан хаагчдын МХТ-ийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх
- 5) Төрийн төв болон орон нутгийн байгууллагаас иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагуудад үзүүлэх үйлчилгээг боловсронгуй болгох
- 6) Цахим ардчиллыг хөгжүүлэх

#### **Төрийн байгууллагын вэб сайтыг сайжруулахад анхаарах асуудлууд**

##### *Байгууллагын дүрэм журам, төлөвлөгөөг боловсронгуй болгох чиглэлээр:*

- Вэб сайтыг ажиллуулах журам боловсруулах түүнийг мөрдөх,
- Төлөвлөгөөтэй болох. Байгууллага бүр өөрсдийн вэб сайтыг сайжруулах, вэб сайт ажиллуулах үйл ажиллагаануудыг улирлын болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж байх хэрэгтэй.
- Ажил үүргийн хуваарийг тодорхой болгох.
- Хууль, тогтоолд заасан мэдээллийг вэб сайтад бүрэн гүйцэд байрлуулах.

##### *Иргэд, хэрэглэгчдийн оролцоог хангах чиглэлээр:*

- Хэрэглэгчид вэб сайтаар дамжуулан мэдээлэл авах, хүсэх үйл явцыг тодорхой болгох,
- Вэб сайтад иргэдийн оролцоог хангасан сувгуудыг бий болгох. Үүнд вэб сайтад асуулт хариултын булантай болох, форумтай болох, мөн иргэдийн портал системтэй болох боломжтой. Портал системтэй болно гэдэг нь их хэмжээний мэдээлэл, үйлчилгээ зэргийг хэрэглэгчдэд ашигтай, ойлгомжтой байдлаар нэгтгэсэн байх алхам болох юм.

##### *Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах чиглэлээр:*

- Төрийн албан хаагчдын дунд сургалт зохион байгуулах. Төрийн байгууллагын анхан шатны нэгж болгоны нэгээс доошгүй мэргэжилтнийг иргэдтэй онлайн харилцаа үүсгэх сургалт зохион байгуулах.

- Вэб сайт хариуцсан мэргэжилтнийг сургах.
- Удирдлагуудын дунд нөлөөллийн ажил явуулах. Төрийн байгууллагын салбар /хэлтэс удирдах албан тушаалтнуудыг хамарсан сургалтаар дамжуулан удирдлагуудын зүгээс энэхүү асуудалд илүү анхаарал хандуулахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг явуулах хэрэгтэй.

*Төрийн байгууллагын вэб сайтын ил тод байдлыг үнэлэх хяналт, шинжилгээ үнэлгээг боловсронгуй болгох чиглэлээр:*

- Хэрэглэгчдийн хэрэгцээг хангасан байдлын талаарх шалгуур үзүүлэлтийг нэмэх. Төрийн байгууллагын вэб сайт дахь мэдээллийн ил тод байдлыг хангахад хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага ямар байгаа талаар мэдээлэл, мэдлэгтэй болох шаардлагатай.
- Мониторингийг тогтмолжуулах, бусад хяналт шинжилгээний ажлуудтай уялдуулах.
- Байгууллагын дотооддоо хяналт шинжилгээг хийдэг болох. Түүнчлэн төрийн байгууллагууд дотооддоо вэб сайтанд тавигдах мэдээлэл, түүний чанарт тавих хяналтын механизмыг бий болгох, сайжруулах нь чухал байна.